



МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ

*“Монголын төмөр зам” ТӨХК-ийн 2025 оны 4 дүгээр улирлын
байдлаар “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай
хууль”-ийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ
хийсэн тухай тайлан*

2025 он

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Дотоод аудитын зорилго, үндэслэл:

Зам, тээврийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/310 дугаар тушаалын 5 дугаар хавсралтыг үндэслэн 2025 оны 4 дугаар улирлын байдлаар мэдээллийн ил тод, нээлттэй байдлын тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит, хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчил дутагдлуудыг засаж сайжруулан хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар санал дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулах.

Дотоод аудитад дараах хууль, дүрэм, журам, эрх зүйн баримт бичгүүдийг удирдлага болгон ажиллав. Үүнд:

“Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хууль,

“Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан Дотоод аудитын дүрэм”,

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх”, “Үнэлгээ хийх журам”, “Хяналт-шинжилгээ хийх журам”-ыг тус тус үндэслэн дотоод аудит, хяналт шалгалтыг явуулав.

1.2. Дотоод аудитын бүрэлдэхүүн, ажилласан хугацаа:

“Хяналт шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн Л.Ууганцэцэг 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдрийг дуусталх хугацаанд ажиллав.

1.3. Дотоод аудитад хамрагдсан асуудлууд:

Байгууллагын хэмжээнд 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар мэдээллийн ил тод, байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангасан талаарх Гадаад харилцаа, олон нийттэй харилцах хэлтсээс ирүүлсэн хэрэгжилтийн тайлан, мэдээлэл. Үүнд:

Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал,

Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал,

Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал,

Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байдал,

Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал, тоо батлах, ажлын хэсэг байгуулах, шагнал урамшуулал олгох хүмүүсийн нэрс гэх мэт дээрх мэдээллүүдэд баримт бичгийг хавсаргасан байдал зэргийг шалгав.

1.4. Арга зүй, стандартын талаарх мэдээгдэл:

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх”, “Үнэлгээ хийх журам”, “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 3 дугаар хавсралт, “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6 дахь хэсэгт тус тус заасны дагуу төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад 48 төрлийн мэдээллийг ил тод, нээлттэй байлгахгаар заасан мэдээллийг хэрхэн цахим хуудсанд байршуулсан байдал, зэрэгтэй танилцаж, холбогдох мэдээлэлтэй тулган баталгаажуулав.

Хоёр.Бодит байдал

2.1. Үндсэн мэдээлэл

“Мэдээллийн ил тод байдлын тухай хууль” үйлчилж эхэлснээс хойш 2023 оноос эхлэн Нийтэд нээлттэй мэдээлэх, хуульд ил тод, нээлттэй байхаар заасан, эсхүл хязгаарлалттай болон хаалттай мэдээлэлд хамаарахгүй мэдээллийг холбогдох хууль, дүрэм, журмыг мөрдөж байршуулан хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгоход хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тайлант хугацаанд мэдээллийн ил тод, нээлттэй байдлын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээг хавсралтаас харах.

ДҮГНЭЛТ:

"Монголын төмөр зам" ТӨХК-ийн "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль"-ийн хэрэгжилтийг 2025 оны IV улирлын байдлаар нийт 46 арга хэмжээний хүрээнд дүгнэхэд хэрэгжилт 94,1 хувьтай байна.

Шалгуур: “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”, Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх”, “Үнэлгээ хийх журам”, “Хяналт-шинжилгээ хийх журам”, Зам, тээврийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/310 тушаалаар батлагдсан “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж дүгнэх журам”

Шалтгаан: Хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй байгаа нь 2025 оны III улирлын байдлаар хийсэн хяналт, шалгалтаар өгсөн зарим зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байх, иргэд олон нийтэд мэдээлэл авах боломжоор дутмаг. Компанийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт бүрэн хангагдахгүй байх зэрэг шалтгаан болж байна.

Гурав. Дүгнэлт

Дүгнэлт 1: Бүлэг-1 Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдалд хийсэн үнэлгээ 83,74 хувьтай, 8.2.4-т заасан /хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан/ мэдээлэл огт оруулаагүй, 8.2.7-д заасан /албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг/-д оруулсан мэдээлэл дутуу, 8.2.8-д заасан /өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ/-д мэдээлэл шаардлага хангахгүй, өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийгээгүй мэдээлэл байршуулсан.

Дүгнэлт 2: Бүлэг-2 Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдалд хийсэн үнэлгээ 93,75 хувьтай байна. 8.3.5-д заасан /хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ/-д Мэдээллийн бүрэн байдал хангагдаагүй мэдээлэл байршуулсан.



MONGOLIAN TETHER SAM

- Дүгнэлт 3: Бүлэг-3 Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдалд хийсэн үнэлгээ 95,2 хувьтай хангалттай. 8.4.4-д заасан /хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ/ хамааралгүй холбоосыг оруулсан.
- Дүгнэлт 4: Бүлэг-4 Үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байдалд хийсэн үнэлгээ 100 хувьтай. Өмнөх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлж ажилласан. Хуулийн 8.6.5, 8.6.6, 8.6.8-д тус тус заасан мэдээлэл дутуу, огт оруулаагүй байсныг нөхөж оруулсан.
- Дүгнэлт 5: Бүлэг-5 Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдалд хийсэн үнэлгээ 97,9 хувьтай мэдээлэл дутуу байршуулсан. 8.6.21-д заасан /мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцсан болон суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт/-мэдээлэл дутуу байршуулсан. Мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангаагүй.

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн хэмжээнд “Мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-ийн хэрэгжилтийн үнэлгээ 4 дүгээр улирлын байдлаар 94,1 хувьтай байгаа нь цахим хуудсанд байршуулсан мэдээллийг ил тод, нээлттэй нийтэд үнэн зөв, шуурхай хүргэх байдал хангагдсан.

Дөрөв. Зөвлөмж:

/ЗУГ, СХОТГ, ТУГ, СБГ, ХБГ, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГА НАР/-Т

- Зөвлөмж 1: Цаашид “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангуулах үүрэг бүхий Гадаад харилцаа, олон нийттэй харилцах хэлтэс нь хавсралтад дурдсан мэдээллийг WWW.MTZ.MN цахим хуудсанд хууль тогтоомжид заасан хугацаанд мэдээллийг шинэчлэн байршуулах ажлыг удирдлага зохион байгуулалтаар ханган, ажиллаж, Хяналт шалгалтын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилгаж, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 01 дүгээр улиралд багтаан Хяналтын албанд ирүүлэх.
- Зөвлөмж 2: Цахим хуудсанд мэдээлэл байршуулахад тухайн мэдээлэл хариуцсан нэгжийн дарга нар болон цахим хуудсанд мэдээлэл байршуулах албан хаагч мэдээллийг шинэчлэн байнгын сайжруулалт хийж, дутуу буруу оруулсан, алдаатай холбоосыг зөвлөмжийн дагуу засаж, байршуулж хэвших.

Хавсралт 3 хуудастай.

ТАНИЛЦСАН:
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ХЯНАСАН:
ХЯНАЛТЫН АЛБАНЫ ДАРГА

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН

О.БАТЧУЛУУН

С.НЯМБАЯР

Л.УУГАНЦЭЦЭГ

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг тайлан

2025 оны 12 дугаар сарын 12

	№	Шалгуур үзүүлэлт	Хувь	Холбоос	2025 оны 12 дугаар сарын 12
					Хяналт алба
8.2 Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	8.2.1	Эрхэм зорилго, танилцуулга	95,8%	https://www.mtz.mn/pages/about-us	
	8.2.1	Үйл ажиллагааны стратеги зорилго		https://mtz.mn/transparency/jl-azh-1	
	8.2.1	Үйл ажиллагааны стратеги зорилт		https://mtz.mn/transparency/jl-2	
	8.2.1	Тэргүүн чиглэл		https://www.mtz.mn/pages/about-us	
	8.2.2	Бүтэц, зохион байгуулалт	100%	https://www.mtz.mn/pages/about-us	
	8.2.2	Хаяг, байршил		http://mtz.mn/contact-us	
	8.2.2	Харилцах утасны дугаар		http://mtz.mn/contact-us	
	8.2.2	Шуудангийн хаяг		http://mtz.mn/contact-us	
	8.2.2	Олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг		http://mtz.mn/contact-us	
	8.2.3	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт	100%	Монголын төмөр зам ТӨХК	
	8.2.3	Үйл ажиллагааны тайлан		https://mtz.mn/pages/about-us	
	8.2.3	Мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ		https://mtz.mn/transparency/category/hudaldan-awalt	
	8.2.3	Дотоод аудит		Монголын төмөр зам ТӨХК	
	8.2.3	Санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж		Монголын төмөр зам ТӨХК	
8.2.4	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан	0%	Мэдээлэл байршуулаагүй.		
8.2.5	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан	100%	https://mtz.mn/transparency/h-gzhlijn-bodlogo-t-l-vl-ltijn-barimt-bichig-t-s-l		
8.2.6	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж		https://mtz.mn/career		
8.2.6	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт	100%	https://mtz.mn/legal		
8.2.7	Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг	100%	https://mtz.mn/career	Оруулсан мэдээлэл дутуу. Ажилтны утасны дугаар байхгүй. Мэдээллийг шинэчилж бүрэн оруулах.	
8.2.8	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ	41.60%	https://mtz.mn/career	Мэдээлэл шаардлагад хангахгүй. Цаашид мэдээлэл хариуцагч нэгж нь өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж, албажуулсан мэдээллийг цахим хуудсанд байршуулах.	
8.2.9	Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл	100	https://mtz.mn/transparency/category/teeverlellin-uil-ajillagaa		
8.2.10	Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр	100	https://mtz.mn/transparency/category/b-1		
8.3 Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	8.3.1	Ажлын байрны сул орон тооны талаар мэдээлэл	100%	https://mtz.mn/career	
	8.3.2	Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам	100%	https://res.cloudinary.com/dlo8veppc/image/upload/v1763436974/songon_shalgaruulalt_zasah_0622d5a681.pdf	
	8.3.3	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм	100%	https://res.cloudinary.com/dlo8veppc/image/upload/v1762222662/A94_Yos_z_jn_d_rem_1_1_68e6b91c3b.pdf	
	8.3.4	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам	100%	https://www.mtz.mn/career	
	8.3.5	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ	62,5%	https://www.mtz.mn/career	Мэдээлэл шаардлагад хангахгүй. Цаашид мэдээлэл хариуцагч нэгж Хүний нөөц, сургалтын хэлтсийн 2025 онд хийсэн ажлын тайланг байршуулах. 2024 оны мэдээллийг шинэчлэх.
	8.3.6	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам		https://res.cloudinary.com/dlo8veppc/image/upload/v1679537601/7_418fd139ad.pdf	

8.4 Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	8.4.1	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухай жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл	100%	https://shilendans.gov.mn/organization/26012?ry=2024&group=5	
	8.4.1	Тухай жилийн төсөв		Монголын төмөр зам	
	8.4.1	Дараа оны төсвийн төсөл		Монголын төмөр зам	
	8.4.2	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан	100%	https://mtz.mn/transparency/category/sanh	
	8.4.3	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	100%	https://mtz.mn/transparency/category/sanh	
	8.4.4	Хууль тогтоомжийн дагуу төлбөр хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсийн хэмжээ	100%	https://shilendans.gov.mn/organization/34795?ry=2024&group=117	Хамааралгүй холбоос оруулсан.
	8.4.4	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ		Монголын төмөр зам ТӨХК	Мэдээлэл шинэчлэх.
8.4.5	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгаан	100%	Монголын төмөр зам		
8.4.6	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санжүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	100%	Монголын төмөр зам		
8.4 Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	8.4.7	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт	100%	https://shilendans.gov.mn/organization/26012?ry=2025&group=5	
	8.4.8	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, коцесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр	100%	Монголын төмөр зам	
	8.4.9	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл	58,3%	https://mtz.mn/transparency/category/hudaldan-awalt	Хамааралгүй холбоос оруулсан.Аудитын тайлан, зөвлөмжийн биелэлтийг оруулах.
	8.4.10	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	100%	https://mtz.mn/transparency/category/hudaldan-awalt	
	8.4.10	Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам		https://www.tender.gov.mn/mn/rules/list	
	8.4.10	Тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт		https://user.tender.gov.mn/mn/invitation?year=2025&selGovernorId=158&selClientId=1453535505113&get=1	
	8.4.10	Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл		Монголын төмөр зам ТӨХК	
	8.4.10	Шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан		Монголын төмөр зам ТӨХК	
	8.4.11	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт	100%	Монголын төмөр зам	
	8.4.12	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл	100%	https://mtz.mn/transparency/category/hudaldan-awalt	
	8.4.26	Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн		Хамааралгүй	
	8.4.27	Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан	100	Монголын төмөр зам ТӨХК	
8.5 Үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байдал	8.5.1	Үйлчилгээний төрөл	100%	https://mtz.mn/transparency/category/teeverleltii-n-uil-ajillagaa	
	8.5.1	Шийдвэрлэх журам, хугацаа		Монголын төмөр зам ТӨХК	
	8.5.1	Бүрдүүлэх баримт бичиг		Монголын төмөр зам ТӨХК	
	8.5.1	Түүний заавар		Монголын төмөр зам ТӨХК	
	8.5.1	Төлбөр хураамж зохицуулалтын үйлчилгээний хөлсийн хэмжээ		https://mtz.mn/transparency/category/teeverleltii-n-uil-ajillagaa	
	8.5.1	Төлбөр төлөх дансны мэдээлэл		Монголын төмөр зам ТӨХК	
	8.5.2	Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам			https://mtz.mn/transparency/category/teeverleltii-n-uil-ajillagaa
8.6.1	Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал /хамаарахгүй/		Хамааралгүй		

8.6 Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	8.6.2	Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт	100%	Монголын төмөр зам ТӨХК	
	8.6.3	Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл /Хамаарахгүй/		Хамааралгүй	
	8.6.4	Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл	100%	Монголын төмөр зам ТӨХК	
	8.6.5	Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдс	100%	https://mtz.mn/transparency/category/huul-zaasan-busad-medeeel	
	8.6.5	Дүрэм			
8.6.5	Үйл ажиллагааны чиглэл				
8.6.5	Эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан				
	8.6.5	Нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг			
8.6 Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	8.6.6	төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл	100%	https://mtz.mn/transparency/category/huul-zaasan-busad-medeeel	
	8.6.8	Монголын төмөр зам ТӨХК Монголын төмөр зам ТӨХКТөрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүний ашиглалтаас гарах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл	100%	Монголын төмөр зам ТӨХК Монголын төмөр зам ТӨХК	
	8.6.10	Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл	100%	Монголын төмөр зам ТӨХК	
	8.6.11	Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт	100%	Монголын төмөр зам ТӨХК	
	8.6.13	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ		Хамааралгүй	
	8.6.21	Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт	75%	https://mtz.mn/career	Мэдээлэл дутуу, мэдээллийн бүрэн бүтэн байдал алдагдсан. Мэдээллийг бүрэн байршуулах. Эх сурвалжийн мэдээлэл байршуулаагүй.
	8.6.22	Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл	100%	https://mtz.mn/transparency/category/b-1	

Хэрэгжилтийн дундаж хувь 94,1.

ДҮГНЭЛТ:

"Монголын төмөр зам" ТӨХК-ийн "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль"-ийн хэрэгжилтийг 2025 оны III улирлын байдлаар нийт 48 арга хэмжээний хүрээнд дүгнэхэд хэрэгжилт 94,1 хувьтай байна.

ХЯНАЛТЫН АЛБА